



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР
НӨЛӨӨ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БНА-2022/30-ШТА-ГА

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ,
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНГИЙН ТАЛААР ИРГЭДЭД ХҮРЭХ МЭДЭЭЛЭЛ ХАНГАЛТГҮЙ
БАЙНА.**

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор **Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер **А.Цээням**

Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn

Ахлах аудитор **Б.Азбаяр**

Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn

Аудитор **Б.Нарангэрэл**

Утас: 99009293 цахим хуудас: narangerelb@audit.gov.mn

Аудитор **Н.Бүнчинсүрэн**

Утас: 99009293 цахим хуудас: bunchinsurenn@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН ЭСЭХ	5
1.1. Орон нутгийн нэгдсэн сангаас олгогдох орлогын шилжүүлэг бүрэн олгогдож байгаа ч орон нутаг баталгаагүй эх үүсвэрийг төлөвлөж байна.	5
1.2. Зарим сумд иргэдээс санал аваагүй, ТЭЗҮ зураг төсөв хийгдээгүй төсөл арга хэмжээг төлөвлөж, ИТХ-аар батлуулсан нь төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.....	7
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНГ ТООЦООЛОХГҮЙ БАЙНА.....	12
2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийг зөрчсөн байна.	12
2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрэх үр дүнг нэгтгэж, үр дүнг тооцоогүй байна.	17
2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон зарим төсөл, арга хэмжээний техникийн үндэслэл, чанар байдалтай холбоотойгоор ашиглалт хангалтгүй байна.	19
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЖ, ТАЙЛАГНАСАН ЭСЭХ.....	21
3.1. Аймгийн ИТХ ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд хяналт тавиагүй, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд тавих хяналт хангалтгүй байна.....	21
3.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу тайлагнасан байна.	27
ДҮГНЭЛТ:	32
ЗӨВЛӨМЖ:	33

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ХБТХОТ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу хийж гүйцэтгэв.</p>
Аудитын зорилт	<p>Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">➤ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;➤ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;➤ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	<p>ОНХС-ийн 2021 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал болон Сангийн яам болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, ЗДТГ, баг, хороодын ИНХ, Засаг даргын холбогдох үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлийн аудитыг хийв.</p> <p>ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дэд тайлан, илрүүлэлтийн матрицыг боловсруулан гүйцэтгэлийн аудитын үр дүнг нэгтгэв.</p>
Аудитын хязгаарлалт	<p>Аудитад 2021 онд хэрэгжүүлэхээр аймаг, сумын ИТХ-аар баталсан хөрөнгө оруулалтын ТАХ-нээс бусад тайлант он болон эх үүсвэрээр хийгдсэн төсөл, арга хэмжээг хамааруулаагүй болно.</p>
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	<p>Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авч, харьцуулалт хийн, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.</p>
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	<p>Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цээням хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Б.Нарангэрэл, Н.Бүнчинсүрэн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.</p> <p>Аудитын талбарын үе шатны ажлыг 2022 оны 05 дугаар сарын 05-аас эхлэн гүйцэтгэсэн ба аудиторууд талбарын ажлын явцад дэд тайлангийн төслийг бичиж, аудитын тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар 06 дүгээр сарын 02-ны өдөр хэлэлцүүлж, тайланг баталгаажуулан Баянхонгор аймаг дахь</p>

**Хүндрэл
бэрхшээл**

Төрийн аудитын газар болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Баянхонгор аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлттэй холбоотой зарим баримт материалыг аудитын явцад олдохгүй байсан нь хүндрэл учруулж байв.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ХИЙХДЭЭ ИРГЭДИЙН САНАЛ АВААГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСАН БАЙНА.

1.1. Орон нутгийн нэгдсэн сангаас олгогдох орлогын шилжүүлэг бүрэн олгогдож байгаа ч орон нутаг баталгаагүй эх үүсвэрийг төлөвлөж байна.

1.1.1. Орон нутгийн нэгдсэн сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийг орон нутгийн түвшинд тодорхой мэдээлэл байхгүй бөгөөд ОНХС-гийн нэгтгэсэн тайланд авч үзнэ.

1.1.2. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу Сангийн яамнаас тооцоолол хийж ирүүлсний дагуу хуваарилж байна.

Монгол улсын 2021 оны Төсвийн тухай хуульд улсын төсвөөс Баянхонгор аймагт ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 7,781.6 сая төгрөгөөр баталсан ба 2021 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн дээрх нэмэлт өөрчлөлтөөр 310.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 8,091.9 сая төгрөгөөр баталсан байна.

Хуваарилагдсан төсвийг Баянхонгор аймгийн ОНХС-д 4,594.6 сая, 20 сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн 2,862.0 сая, Төсвийн тухай хуулийн 58.2.12¹-т заасан мал эмнэлгийн үйлчилгээний зардалд 548.1 сая, 58.2.15²-д заасны дагуу хот тохижилт үйлчилгээний зардалд 87.2 сая төгрөгийг зарцуулахаар Аймгийн ИТХ-ын 2021 оны 4/15 тоот тогтоолоор баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 59.3³ дахь заалт, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу орлогын шилжүүлгийн тооцооллыг Сангийн яамнаас хийж ирүүлснийг үндэслэн аймгийн СТСХ-ээс сумдад шилжүүлэг олгосон байна.

1.1.3. Баянхонгор аймаг нийт 20 сумд 2,862.0 сая төгрөгийг хуваарилахаар баталсныг хуваарийн дагуу бүрэн олгосон байна.

¹ 58.2.12. мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;

² 58.2.15. аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах;

³ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

Сумдад олгосон дүнгээс харахад Баянхонгор сум хамгийн их буюу 309.8 сая, Заг сум хамгийн бага буюу 68.9 сая төгрөг хуваарилсан байна.

Хүснэгт №1. Сумдад батлагдсан ОНХС-гийн шилжүүлэг

№	Сумдын нэр	Орлогын шилжүүлэг		Урамшуулал		Дэмжлэг		Нийт	
		төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Баянхонгор сум	213.2	213.2	77.1	77.1	19.5	19.5	309.8	309.8
2	Баацагаан сум	141.7	141.7	27.7	27.7	7.0	7.0	176.3	176.3
3	Баянбулаг сум	58.3	58.3	17.8	17.8	4.5	4.5	80.6	80.6
4	Баянговь сум	251.1	251.1			6.7	6.7	257.8	257.8
5	Баянлиг сум	136.3	136.3	42.0	42.0	10.6	10.6	188.9	188.9
6	Баян-Овоо сум	75.6	75.6	12.4	12.4	3.1	3.1	91.1	91.1
7	Баян-Өндөр сум	242.9	242.9			11.1	11.1	253.9	253.9
8	Баянцагаан сум	154.7	154.7	32.5	32.5	8.2	8.2	195.4	195.4
9	Богд сум	57.1	57.1	12.9	12.9	5.2	5.2	75.2	75.2
10	Бөмбөгөр сум	137.2	137.2	18.7	18.7	4.7	4.7	160.7	160.7
11	Бууцагаан сум	85.5	85.5	30.1	30.1	7.6	7.6	123.1	123.1
12	Галуут сум	90.2	90.2	23.3	23.3	5.9	5.9	119.4	119.4
13	Гурванбулаг сум	64.2	64.2	27.1	27.1	5.5	5.5	96.8	96.8
14	Жаргалант сум	68.1	68.1	27.7	27.7	5.6	5.6	101.4	101.4
15	Жинст сум	57.0	57.0	16.8	16.8	4.2	4.2	78.1	78.1
16	Заг сум	44.8	44.8	20.1	20.1	4.0	4.0	68.9	68.9
17	Өлзийт сум	76.5	76.5	20.1	20.1	4.1	4.1	100.7	100.7
18	Хүрээмарал сум	57.7	57.7	18.0	18.0	4.5	4.5	80.2	80.2
19	Шинэжинст сум	218.5	218.5			10.3	10.3	228.8	228.8
20	Эрдэнэцогт сум	51.4	51.4	18.6	18.6	4.7	4.7	74.7	74.7
	Дүн	2,282.0	2,282.0	442.8	442.8	137.0	137.0	2,862.0	2,862.0

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол

1.1.4. Баянхонгор аймгийн болон сумдын орон нутгийн хөгжлийн санд нийт 1,737.1 сая төгрөгийн бусад эх үүсвэрээр орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн эх үүсвэрийг төрөл тус бүрээр нь авч үзвэл:

Хүснэгт № 2. Орон нутгийн хөгжлийн санд төвлөрч буй бусад орлого

Аймаг, сумдын нэрс	Малжуулах болон Өвс тэжээлийн эргэн төлөлтийн орлого		Хандив		Орон нутгийн давсан орлогоос		Төлбөрийн акт болон дуудлага худалдааны төвлөрсөн орлого		Малын тоо толгойн албан татварын орлогоос		Нийт	
	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц
Аймгийн ОНХС			577.2	84.0	495.2	284.6					1,072.37	368.6
Баянхонгор сум					17.3	17.3		3.8		0.7	17.30	21.7
Баацагаан сум	53.3	40.1									53.30	40.1
Баянбулаг сум											-	-
Баянговь сум	9.8	0.4									9.80	0.4
Баянлиг сум		54.8									-	54.8
Баян-Овоо сум			125.0	55.0							125.00	55.0
Баян-Өндөр сум	8	31			32.9	32.9					40.90	63.9

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

Баянцагаан сум								22.1			-	22.1
Богд сум		4.4									-	4.4
Бөмбөгөр сум	17	12.9			74.0	74.0					91.00	86.9
Бууцагаан сум				85.0							-	85.0
Галуут сум		18.8	120.0	45.0							120.00	63.8
Гурванбулаг сум	8.6	8.6							35.0	35.0	43.60	43.6
Жаргалант сум	17.5	23.8			10.0	10.0		3.775			27.50	37.6
Жинст сум	6.3	6.3									6.30	6.3
Заг сум		0.2			9.8	9.8		3			9.77	13.0
Өлзийт сум	12.8	13.6			8.5	8.5					21.30	22.1
Хүрээмарал сум	50.0	41.1									50.00	41.1
Шинэжинст сум	49.0	35.1									49.00	35.1
Эрдэнэцогт сум		8.5									-	8.5
Аймгийн дүн	232.3	299.6	822.2	269.0	647.6	437.1	-	32.7	35.0	35.7	1,737.14	1,074.0

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоолууд,

Орон нутгийн хөгжлийн сангаас олгосон малжуулах төслийн эргэн төлөлтийн орлого, худалдан авсан өвс тэжээлийн орлогыг зарим сум санд оруулахаар төлөвлөөгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант онд өвс тэжээлийн эргэн төлөлтийн орлогыг төлөвлөөгүй боловч гүйцэтгэлээр Баянлиг сум 54.8 сая, Богд сум 4.4 сая, Галуут сум 18.8 сая, Эрдэнэцогт сум 8.5 сая төгрөг тус тус санд төвлөрсөн.

Иймд иргэдэд эргэн төлөгдөх өвс тэжээл болон малжуулах төслийн орлогыг төлөвлөж байх зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

Аймгийн хэмжээнд ОНХС-д хандив тусламжаар 822.2 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс 269.0 сая төгрөг төвлөрсөн нь тухайн хандив тусламжийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй эрсдэлтэй нөхцөл байдал үүсэж байна.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн орон нутгийн хөгжлийн санд 577.2 сая хандив авахаар төлөвлөсөн боловч 84.0 сая төгрөгийн хандивыг уул уурхайн компаниудаас орсон, Баян-Овоо сум 125.0 сая төгрөгийн хандив авахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 55.0 сая төгрөгийг Наранмандал энтерпрайзес ХХК-аас, Галуут сум 120.0 сая төгрөгийн хандив авахаар төлөвлөсөн боловч 45.0 сая төгрөгийн хандив “Шижир аранжин” ХХК-аас тус тус төвлөрсөн байна.

Иймд ОНХС-гийн эх үүсвэрийг төлөвлөхдөө бодитой, орох боломжтой байдлаар төлөвлөж байх зөвлөмжийг аймаг, сумдын Засаг дарга нарт өгөв.

1.2. Зарим сумд иргэдээс санал аваагүй 337.3 сая төгрөгийн 28 ТАХ, ТЭЗҮ зураг төсөв хийгдээгүй 434.6 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулсан нь Төсвийн тухай хуулийн 29.4, 60.3.6 дахь заалтыг зөрчсөн байна.

1.2.1. Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах зайлшгүй шаардлагатай.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь багийн ИНХ-аас авсан санал, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр сумдаас ирүүлсэн төсөл арга хэмжээний саналд үндэслэн төлөвлөсөн байна.


Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь иргэдээс нэг цэгийн үйлчилгээний цэгээр авсан санал, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр сумдаас ирүүлсэн төсөл арга хэмжээний саналд үндэслэн төлөвлөсөн байна.

Зарим сумд тайлант онд иргэдээс санал авч, эрэмбэлээгүй ТАХ-г ИТХ-аар баталсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитын илрүүлэлт:

1. Бууцагаан сум: Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд 36.0 сая, Хог хаягдал орчны бохирдол бууруулахад 9.0 сая, Гудамж төсөл хэрэгжүүлэхэд 15.0 сая, нийтийн бие засах газар хогийн цэг байгуулахад 5.0 сая сумын төвийн камержуулалт засварт 3.5 сая, Тариалангийн талбайн суваг шуудуу янзлахад 1.5 сая нийт-70.0 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээг иргэдээс санал аваагүй;
2. Заг сум: Соёлын төвийн тоног төхөөрөмжийн 14.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг иргэдээс санал аваагүй;
3. Баян-Овоо сум: Тухайн онд батлагдсан ажилд иргэдээс санал авсан ажлыг оруулаагүй нийт 187.1 сая төгрөгийн өртөг бүхий 10 төсөл арга хэмжээг иргэдийн саналгүй ИТХ-ын хуралдаанаар батлуулсан байна
4. Жаргалант сум: Гэрэлтүүлгийн 3.3 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг иргэдээс санал аваагүй;
5. Жинст сум: “Нийтийн ариун цэврийн байгууламж” 10.0 сая, худгийн халаалт 5.0 сая, нохой устгах зардал 1.9 сая, гамшгаас урьдчилан сэргийлэх гамшигийн хор хохирлыг арилгах зардалд 16.0 сая, нийт 33.0 сая төгрөгийн 4 ТАХ-нд иргэдийн санал аваагүй;
6. Баацагаан сум: Цагдаагийн Согтуурал шалгааг багаж"-ийн 2.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тоног, төхөөрөмжийг иргэдээс санал аваагүй;
7. Баянцагаан сум: Хөргүүртэй контейнерын 20.0 сая төгрөгийн өртөг бүхий арга, хэмжээг иргэдээс санал аваагүй;
8. Баянлиг сум: Цаг уурын талбай засварлах 8.0 сая төгрөгийн ТАХ-нд иргэдээс санал аваагүй


Харин зарим сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдээс санал авч эрэмбэлэхдээ хүртээмжтэй байдлаар санал аваагүй тоогоор хязгаарласан, бүх багаас санал аваагүй зөрчил илэрч байна.



Энэ талаар иргэдээс авсан санал асуулгын дүнгээр иргэдийн дийлэнх хувь нь оролцдоггүй, мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Санал асуулгын дүгээс харахад баг хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хамгийн түрүүнд хийх

⁴ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

шаардлагатай “ТАХ-ны саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулдаг уу” гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 38 хувь нь санал авдаг гэж хариулсан бөгөөд 40 хувь нь санал өгөх үйл ажиллагаанд оролцдог гэж хариулсан байна.



Мөн Засаг дарга иргэдээс авсан саналыг эрэмбэлж, хамгийн их санал авсан ажлуудыг иргэдэд нээлттэй танилцуулсан эсэхэд нийт судалгаанд оролцогчдын 27 хувь нь тийм гэж хариулсан бол 46 хувь нь мэдэхгүй гэж хариулснаас харахад эрэмбэлсэн ТАХ-г иргэдэд танилцуулах ажил хангалтгүй байгааг харуулж байна.

Аудитын илрүүлэлт:

1. Богд сум: 1, 3 дугаар багийн иргэдээс санал аваагүй байгаа нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар эрэмбэлээгүй байна.
2. Баянхонгор сум: Иргэдээс санал авахдаа 1 багаас 500 саналын хуудас тарааж, нийт 10 багаас 5000 ширхэг саналын хуудас авч эрэмбэлэн ИТХ-д өргөн барьсан. ТАХ-ний жагсаалтыг өргөн барихдаа дүнг нэгтгээгүй байна. Нэг багаас тогтмол тоогоор санал авч байгаа нь иргэдийг хүртээмжтэй байдлаар санал авахгүй байна.

Мөн Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ийн 6.3⁵, 6.4⁶ дэх заалтыг зөрчиж, журамд заасан үзүүлэлт тус бүрээр эрэмбэлээгүй, эрэмбэлсэн жагсаалтыг ажлын хэсэг баталгаажуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

1. Баян-Өндөр сум: Сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилоогүй байхад тухайн үед ажиллаж байсан санхүүгийн албаны дарга, орон нутаг хариуцсан нягтлан бодогч нар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг эрэмбэлсэн байна.
2. Богд сум: Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нь багийн ИНХ-аас ирүүлсэн саналыг эрэмбэлэхдээ зөвхөн иргэдийн саналын тоогоор эрэмбэлсэн ба сумын Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлээгүй байна.
3. Баянговь сум: Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг эрэмбэлэх ажлын хэсэг нь журмын 6.4-т заасан үзүүлэлтүүдээр эрэмбэлээгүй
4. Шинэжинст сум: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлэх, урьдчилсан жагсаалт боловсруулах ажлын хэсэг нь сум

⁵ Ажлын хэсэг нь энэ журмын 5.13-т заасан баг, хорооны ИНХ-аас ирүүлсэн тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг нэгтгэн эрэмбэлж, нэгдсэн жагсаалтыг жил бүрийн 7 дугаар сард багтаан боловсруулна.

⁶ Ажлын хэсэг нь баг, хороодоос ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан зөвлөмж, дүгнэлт гарган сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ. Үүнд:

6.4.1.Баг, хороодоос ирүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь баг, хорооны иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн эсэх;

6.4.2.Сум, дүүргийн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдан эсэх;

6.4.3.Энэ журмын 4.6-д заасны дагуу хасагдах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ байгаа эсэх;

6.4.4.Хөрөнгө оруулалтын урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан төслийн төсөвт өртгийн харьцаа.

дүүргийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрэмбэлэсэн боловч гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуульд заасны дагуу иргэдийн саналд үндэслэн баталж, иргэдэд хүргэх мэдээллийг ил тод, хангалттай байдлаар зохион байгуулж байх зөвлөмжийг холбогдох сумдын ИТХ-ын дарга нарт хүргүүлэв.

1.2.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”-ын баримт бичиг, аймаг, сумдын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Баянхонгор аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Харин Баацагаан, Баянцагаан, Баян-Овоо сумд нь хөгжлийн стратеги төлөвлөгөө, хөгжлийн бодлогын богино болон дунд хугацааны баримт бичигтэй уялдуулан төлөвлөөгүй зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- 1. Баацагаан, Баянцагаан: Сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг нь сумын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрэмбэлээгүй,*
- 2. Баян-Овоо: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 70.0 сая төгрөгийн өртөг бүхий Хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөө, 17.0 сая төгрөгийн өртөг бүхий “Эмчийн байрны засвар”-ын ажлууд нь Засаг даргын Сум хөгжүүлэх 2021 оны төлөвлөгөөтэй уялдахгүй байна.*

Иймд Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.4.2⁷-т заасны дагуу сумын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж байх зөвлөмжийг сумын Засаг дарга нарт хүргүүлэв.

1.2.3. Баянхонгор аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр 2021 онд 336 төсөл арга хэмжээг 9,785.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан бөгөөд үүнээс өмнөх оноос шилжсэн 3,628.5 сая төгрөгийн 89 төсөл арга хэмжээ, шинээр хэрэгжүүлэх 6,156.5 сая төгрөгийн 247 төсөл арга хэмжээ байна.

Баянхонгор аймгийн болон сумдын 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

⁷ Сум, дүүргийн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдсан эсэх

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

Хүснэгт №3 Сумдын 2021 онд Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал:

Төсвийн тухай хуульд заасан чиг үүрэг	Тоо	Дүн	Эзлэх хувийн жин
58.4.1. Сумын удирдлагыг хэрэгжүүлэх	14	191.7	6.8
58.4.2. сумын Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах;	2	18.9	0.7
58.4.3. сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалт хийх;	40	579.0	20.4
58.4.4. мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;	25	182.2	6.4
58.4.5. сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх;	11	124.9	4.4
58.4.6. сумын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах;	7	63.9	2.3
58.4.7. сумын доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгааг хийх, зохион байгуулах;	5	97.3	3.4
58.4.8. сумын тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах арчлах;	26	370.4	13.1
58.4.9. усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх;	22	393.2	13.9
58.4.10. орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх;	40	663.4	23.4
58.4.11. хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	25	148.1	5.2
Нийт	217	2833.0	100.0

Эх сурвалж: 2021 оны ОНХС-ийн судалгаа

Дээрх тооцооллоос харахад Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4.10 “Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх” арга хэмжээнд 23.4 хувь, 58.4.3 “сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалт хийх” чиг үүрэгт хамаарах ажилд 20.4 хувь буюу дээрх чиг үүргийн арга хэмжээнд 579.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

1.2.4. Баянхонгор аймгийн хэмжээнд 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээг хамруулан шалгахад Сумдын ИТХ-ын хуралдаанаар техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсвөө батлуулаагүй 434.6 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээг батлуулж, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Аудитын илрүүлэлт:

1. Жаргалант сум: “Намын давааны засвар”-ын 78.0 сая төгрөгийн өртөг бүхий ТАХ,
2. Заг сум: “Сумын А бүсэд гэрэлтүүлэг тавих” 14.5 сая төгрөгийн өртөг бүхий ТАХ, “Хогийн цэгийг дарж булшлах, шинээр байгуулах” 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ТАХ,
3. Хүрээмарал сум: “Норовлин 3-р багт худаг гаргах” 20.0 сая төгрөгийн ТАХ,
4. Баян-Овоо сум: “Эмчийн байрны засвар”-ны 17.0 сая төгрөгийн өртөг бүхий ТАХ,
5. Галуут сум: “Мал угаалгын ванн”-ны 6 багт хэрэгжүүлэх 120.0 сая төгрөгийн өртөг бүхий ТАХ, “Сип шугамын өргөтгөл”-ийн 18.0 сая төгрөгийн өртөг бүхий ТАХ, “Гэрэлтүүлэг”-ийн 12.0 сая төгрөгийн өртөг бүхий ТАХ, “Зам даваа засварлах” 20.0 сая төгрөгийн өртөг ТАХ,
6. Баянлиг сум: Тухайн жилд хэрэгжих “Хөх модны сувагт гарам тавих”-д 0.4 сая, “Газар тариалангийн услалтын систем сайжруулахад” 1.3 сая, 1 дүгээр багийн төвийн засварт 0.3 сая нийт 2.0 сая төгрөгийг ТАХ-нээс тусад нь баталсан.

7. Баян-Өндөр сум: "Сумын жижиг дунд үйлдвэрлэлийн бизнес хөгжлийн төв барих" ажилд 39.0 сая, "Гар худаг сэргээн засварлах" ажил 10.0 сая, "Сумын нэгдсэн дулааны шугам засвар" 10.0 сая, "Эрүүл мэндийн төвд хүнд өвчтөнг хянах монитор аппарат засвар, мооргийн өрөөний хөргөгч" худалдан авах засварын ажилд 7.0 сая, "Цагдаагийн хэсгийг унаажуулах" төсөл арга хэмжээнд 7.0 сая, "Эрүүл мэндийн төвийн гадна хашаа" 7.5 сая төгрөгийн ТАХ-нүүд Тухайн ТАХ-нүүд нь ТЭЗҮ-гүй батлагдсаны үр дагавраар 55.9 сая төгрөгийн төсөвт өртөө нэмж тодотгосон байна.
8. Баянбулаг сум: "Гудамжны гэрэлтүүлэг"-ийн 10.1 сая төгрөгийн төсөвт өртөө бүхий ТАХ,

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуульд заасны дагуу ТЭЗҮ, зураг төсвийг үндэслэн баталж байх албан шаардлагыг дээрх сумдын ИТХ-ын дарга нарт хүргүүлэв.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНГ ТООЦООГҮЙ БАЙНА.

2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийг зөрчсөн байна.

2.1.1. Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийг шинэчлэн баталсан бөгөөд, тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6,107.7 сая төгрөгийн 248 төсөл арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1⁸-д дагуу сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж нээлттэй тендер шалгаруулалтаар 23 төсөл, арга хэмжээнд 3,352.6 сая төгрөг, харьцуулалтын аргаар 18 төсөл, арга хэмжээнд 608.8 сая төгрөг, 182 төсөл, арга хэмжээнд 1,899.8 сая төгрөгийн шууд гэрээ байгуулжээ.

Нийт 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 73.4 хувьд нь худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байгаа нь сумдын ОНХС-гийн хөрөнгөөр бага үнийн дүнтэй арга хэмжээг баталж хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитаар аймаг, сумын 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 248 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг шалгахад барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн төсвийн жилийн 8,9,10 дугаар сард зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.8⁹ дэх заалтыг зөрчсөн байна.

⁸ 7.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:

⁹ 46.1.8.барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх;

Аудитын илрүүлэлт:

Баянбулаг сум: "Гүн өрмийн худаг Бүрд 4-р баг", "Гүн өрмийн худаг сангийн далай 1-р багт" хийгдэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2021 оны 10 дугаар сард зохион байгуулсан,

1. Жаргалант: "Намын давааны засвар" -ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа 2021 оны 08 дугаар сард зохион байгуулсан,
2. Баацагаан: "Оройн бууц 2-р багт худгийн цооног гаргах", "Товгор 5-р багт худгийн цооног гаргах" ажлын худалдан авах ажиллагааг 2021 оны 9 сард зохион байгуулсан,
3. Баянговь: Гүүрний засварын ажлыг 2021.09.01-нд "Өнөмөнхөд дэлгэрэх" ХХК-тай 10.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан,
4. Богд: 9.0 сая төгрөгийн өртөг бүхий "Худагт уст цэг гаргах" ажлын худалдан авах ажиллагааг 2021 оны 10 сард зохион байгуулсан,

Мөн тендерийн үнэлгээний хороо нь гэрээ байгуулах эрх олгосон, тендерийг сонгон шалгаруулахдаа хууль журам зөрчсөн, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг бөглөөгүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

1. Бууцагаан сум: "Цагаан голын эхийг хамгаалах", "Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх", "Нийтийн эзэмшлийн дэд бүтцийг сайжруулах", ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь гэрээ байгуулах эрхийг олгосон, мөн "Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх" ажлын гүйцэтгэгчээр "Түшээ өргөө трейд" ХХК шалгарсан байхад НАВКА ХХК-д санхүүжилтийг олгосон бөгөөд тендерийн баримт бичигт НАВКА ХХК нь Түшээ өргөө трейд ХХК-тай уг ажил дээр туслан гүйцэтгэх гэрээг байгуулсан байна. Мөн Түшээ өргөө трейд ХХК нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2¹⁰-д заасан сүүлийн 5 жил гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт ирүүлээгүй байхад тус компанийг шалгаруулсан байна.

2. Заг сум: "Эрүүл мэндийн төвд цусны шинжилгээний дэлгэрэнгүй аппарат" нийлүүлэх тендерийн үнэлгээний хороог нийт 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон бөгөөд үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг 3 гишүүн, ашиг сонирхлын зөрчилгүйн мэдэгдлийг 2 гишүүн бөглөөгүй, мөн "Хогийн цэгийг дарж булшлах" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичигт 4 гишүүн үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг бөглөөгүй, ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг 2 гишүүн бөглөөгүй, иргэний төлөөллийг үнэлгээний хороонд оруулаагүй байна.

3. Хүрээмарал: "Норовлин 3-р баг "Цагаан мээмд худаг гаргах" төсөл арга хэмжээний төсөвт өртгийг сумын ИТХ-ын хуралдаанаар 25.0 сая, тухайн онд санхүүжих дүнг 20.0 сая төгрөгөөр баталж "Итгэлт мандал констракшн" ХХК-тай 20.0 сая төгрөгөөр гэрээ байгуулж, шууд худалдан авалт хийсэн байгаа нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4¹¹ дэх заалттай нийцэхгүй байна.

4. Баянцагаан сум: "Ковш машин" 60.0 сая төгрөгийн үнэ бүхий ажлын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг сумын Засаг даргад хүргүүлээгүй, шалгарсан компанид мэдэгдэл хүргүүлж гэрээ байгуулах эрх олгосон байна.

5. Баянхонгор сум: Тайлант онд шинээр хэрэгжүүлэх 255.9 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээнд шууд гэрээ байгуулсан. 7 багт хийгдэх 208.6 сая төрлийн ТАХ-г тендер зарлахдаа ажлыг жижиглэн шууд гэрээ байгуулсан зөрчил илэрсэн.

6. Баянхонгор аймаг: Тайлант онд 249.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Баянхонгор сумын 512 дугаар байрны дээвэр, гадна фасад, агааржуулалт, орц, бохирын шугамыг засварлах /Баянхонгор аймаг. Баянхонгор сум/" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь "Алегротонер констракшн" ХХК-ныг хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгаруулж, аймгийн ЗДТГ-ын даргад зөвлөмж хүргүүлсэн. Харин "Алегротонер констракшн" ХХК нь ажил гүйцэтгэх боломжгүй болсон тул гэрээ байгуулахаас татгалзсан бөгөөд уг ажлыг дараагийн хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж үзэн "Түйн долгио" ХХК-тай 237.0 сая төгрөгөөр гэрээ байгуулсан байна.

¹⁰ сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт;

¹¹ Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно

Гэвч үнэлгээний хороо тус компанийн тендерийн материалыг анх үнэлэхдээ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан чадавхын шаардлагыг хангаагүй гэж үнэлсэн атлаа гэрээг байгуулсан байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлагыг томилсон эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэв.

2.1.2. Баянхонгор аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр 2021 онд 336 төсөл арга хэмжээг 9,785.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсанаас 278 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 12,953.0 сая төгрөгийн гэрээ байгуулж төлөвлөсөн төсөл арга хэмжээнээс 7,500.5 сая төгрөгийн 232 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн ба эдгээрээс 13 төсөл арга хэмжээнд 176.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна. Харин дутуу хэрэгжсэн 5,505.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 48 төсөл, арга хэмжээнд 4,005.0 сая төгрөгийн санхүүжилтийг шилжүүлсэн бөгөөд 1,320.9 сая төгрөгийн 56 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулаагүй, санхүүжилтийг олгоогүй байна.

Аудитаар аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг шалгав.

Тайлант онд ИТХ-аар батлагдсан 17.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний нэр, зориулалт, байршлыг сольж Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9.28¹² дах заалтыг зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

1. Заг сум: бүхий "Соёлын төвийн үзэгчдийн сандлыг шинэчлэх" 14.0 сая төгрөгийн төсөвт өртөг ТАХ-г баталсан байхад соёлын төвийн техник тоног төхөөрөмж худалдан авсан
2. Бууцагаан сум: "Цэцэрлэгийн тоглоомын болон биеийн тамирын талбай байгуулах" 3.0 сая төгрөгийн өртөгтэй ажлын зориулалтыг өөрчилж "замын бродюр болон явган зам" барьсан байна.

Иймд зориулалтыг өөрчлөн хэрэгжүүлсэн дээрх сумдад нэр зориулалтын дагуу төсөл, арга хэмжээг зохион байгуулж байх, буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, санхүүжилт олгохдоо болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1¹³ дэх заалтыг зөрчсөн байна.

¹² Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.

¹³ Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална:

Аудитын илрүүлэлт:

1. Баян-Өндөр сум: Сумын цагдаагийн албан хэрэгцээнд иргэнээс тээврийн хэрэгсэл худалдан авахаар 7.4 сая төгрөгийг шилжүүлсэн анхан шатны баримтад е-баримт байхгүй байгаа тул 0.7 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.
2. Баацагаан сум: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 7 төсөл арга хэмжээний 48.6 сая төгрөгийг шилжүүлэхдээ е-баримт хавсаргаагүй, цахим төлбөрийн баримтын системд бүртгээгүй, хувь хүний орлогын албан татварын 10 хувийг суутган тооцоогүй тул 4.8 сая төгрөгийг орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлэх **төлбөрийн акт** тогтоов.

Анхан шатны баримтын бүрдэлгүй зарлагын гүйлгээг хийж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7¹⁴ дэх заалт, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.13.7¹⁵ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Баянговь сум: Хууль эрх зүйн сургалт зохион байгуулах зардалд 8.0 сая төгрөг батлагдаж, 7.5 сая төгрөгөөр иргэн О.Хумбаантай гэрээ байгуулсан байна. Гэтэл санхүүгийн баримтад бичиг хэрэг болон бусад материалыг нийлүүлсэн анхан шатны баримт байгаа тул **төлбөрийн акт** тогтоов.

Иргэнтэй гэрээ байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн, төсөл арга хэмжээг гүйцэтгэхдээ зах зээлийн үнээс дээгүүр үнээр гэрээ байгуулж, иргэнд шилжүүлсэн, ТАХ-г гүйцэтгээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгож Төсвийн тухай хуулийн 6.4.1¹⁶ дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 8.5¹⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитын илрүүлэлт:

1. Эрдэнэцогт сум: Эрхэт хайрхны багийн тохижилтын ажилд гэрээ байгуулаагүй иргэн Цэрэнпагмад 2.3 сая төгрөг шилжүүлж, сумын ЗДТГ нь материалыг орлого авсан тул сумын ЗДТГ-аас санд буцаан төлүүлэх **төлбөрийн акт** тогтоов.
2. Баянговь сум иргэн О.Эрдэнэбаттай 2021.10.25-ний өдөр Баянговь сумын нутаг дэвсгэр дээр байгаа золбин нохой устгах ажлын гэрээ байгуулахдаа нэг нохойг 0.04 сая төгрөгөөр устгахаар гэрээ байгуулж 8.0 сая төгрөг олгосон бөгөөд бусад сумд нэг нохойг 0.22 сая төгрөгөөр устгасан гэрээ байгуулсан 6.4 сая төгрөгийг илүү шилжүүлсэн тул санд буцаан төвлөрүүлэхээр **төлбөрийн акт** тогтоов.
3. Баян-Овоо сум: Эмчийн байрны засвар хийх ажлыг "Шинэ өлгийн зам" ХХК-тай гэрээ байгуулж санхүүжилтийн 17.0 сая төгрөгийг 2021.09.10-ний өдөр шилжүүлсэн боловч ажил хийгдээгүй байгаа тул буцаан төлүүлэхээр **төлбөрийн акт** тогтоов.

¹⁴ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно

¹⁵ Энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд.

¹⁶ 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

¹⁷ 8.5.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно.

Баянхонгор аймгийн болон Баянхонгор сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг шалгахад гүйцэтгэгч байгууллагууд ажлыг дутуу гүйцэтгэсэн, хүлээлгэж өгөөгүй зөрчлүүд илэрсэн бөгөөд ажлууд бүрэн хийгдээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн Хуримын ордоны гүйцэтгэгч Рокпэйнт ХХК-тай 1,561.3 сая төгрөгөөр гэрээ байгуулж санхүүжилтийг өмнөх онуудад 1,100.0 сая тайлант онд 461.3 сая төгрөгийг авсан боловч ажлын гүйцэтгэл дутуу
- Богд сумын Далан түрүүний 3 дугаар багийн төвийн барилгын ажил 99.6 сая төгрөгөөр хийгдэхээр “Ханзол” ХХК-тай гэрээ хийсэн боловч өмнөх онд 75.0 сая, тайланд онд 10.0 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч ажлыг дуусгаж хүлээлгэн өгөөгүй
- Баянхонгор сумын 7 дугаар багийн төвийн барилгын ажлыг 581.7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр “Стандарт тоосго” ХХК гэрээ байгуулж, 580.7 сая төгрөгийн санхүүжилтийг 3,4,7,9,12 дугаар саруудад авсан боловч ажил бүрэн хийгдээгүй.
- Хүрээмарал сургуулийн дотуур байрны засварын ажлыг 207.7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр “Ар дэн” ХХК-тай гэрээ байгуулж 8, 12 дугаар саруудад санхүүжилтийг бүрэн авсан боловч ажил бүрэн хийгдээгүй
- Эрдэм сургуулийн гаднах спорт цогцолбор талбайн ажлыг 124.6 сая төгрөгөөр гүйцэтгэхээр “Гал гэрэл констракшн” ХХК-тай гэрээг байгуулж 11,12 дугаар саруудад 109.4 сая төгрөгийн санхүүжилтийг авсан боловч ажлыг бүрэн хийгээгүй.
- Эрдэнэмандал сургуулийн гаднах спорт цогцолбор талбайн ажлыг 124.1 сая төгрөгөөр “Есөн од констракшн” ХХК-тай гэрээ байгуулж 50.7 сая төгрөгийн гэрээг байгуулсан боловч ажлыг бүрэн гүйцэтгээгүй байна.

Иймд дээрх бүрэн гүйцэтгээгүй 2,698.9 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээг бүрэн гүйцэтгүүлж хүлээн авч, гэрээнд заасан хариуцлагын арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 7 багт хийгдэх 208.5 сая төгрөгийн 14 багцаар гэрээ байгуулсан “тоглоомын талбайн”-н ажилд нийт 153.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байхад тухайн тухайн арга хэмжээ нь хийгдээгүй байна.

Иймд тухайн тоглоомын талбайн 208.5 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлж хүлээн авч ашиглалтад оруулах албан шаардлагыг Баянхонгор сумын Засаг даргад хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

1. Жинст сум. “Хонгорын шугуй” ХХК-тай нийтийн био нойл хийх 10.0 сая төгрөгийн ажлын гэрээг сумын Засаг даргатай 2021.11.22-ний өдөр байгуулж, 45 хонгийн дотор гүйцэтгэж, урьдчилгааг 100% олгохоор гэрээ байгуулж 9.8 сая төгрөг олгосон боловч тухайн ажил хийгдээгүй тул **төлбөрийн акт** тогтоов.
2. Баянговь сум: Иргэн Б.Жаргалсайхантай 10.0 сая төгрөгийн өртөг бүхий “фитнесийн тоног төхөөрөмж” худалдан авах гэрээ байгуулсан боловч зарим тоног төхөөрөмж ирээгүй байгаа тул дутуу ирсэн тоног төхөөрөмжийг гүйцээн хүлээлгэн өгөх **албан шаардлагыг** хүргүүлэв.

“Баянхонгор Сүмбэр” ХХК нь Баянцагаан суманд “Цэцэрлэгт хүрээлэнгийн дотоод тохижилт”-ийн ажлыг 24.1 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулж урьдчилгаа төлбөрт 12.1 сая төгрөг, Баян-Өндөр сумд ЖДҮ-н бизнес хөгжлийн төв

барих ажлыг 65.7 сая төгрөгийн гэрээ байгуулан 52.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг авсан боловч компанийн захирал нас барсан тул уг ажлууд хийгдээгүй байгаа тул дээрх сумын Засаг дарга нарт хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлэх **зөвлөмж** хүргүүлэв.

2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрэх үр дүнг нэгтгэж, үр дүнг тооцоогүй байна.

2.2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга, хэмжээний үр, ашиг хүртэгчийн тоо болон гарах үр дүнг тухайн үед мөрдөгдөж байсан Сангийн сайдын 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар хавсралтаар баталсан “Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний танилцуулга”-ыг багийн иргэдийн нийтийн хурлаар батлан ирүүлж байгаа бөгөөд түүнд үр ашиг хүртэгчийн тоо болон шийдвэрлэгдэх асуудлыг тусгаж байна.

Хүснэгт № 4. ТАХ-ний хэрэгжилтийн байдал

№	Сангийн нэр	Батлагдсан ТАХ-ний тоо	Хэрэгжилтийн байдал					
			Бүрэн хэрэгжсэн	Хувь	Дутуу хэрэгжсэн	Хувь	Огт хэрэгжээгүй	Хувь
1	Баянхонгор аймаг	64	49	76.6	14	21.9	1	1.6
2	Баянхонгор	19	4	21.1	15	78.9	0	0.0
3	Баацагаан	15	7	46.7	4	26.7	4	26.7
4	Баянбулаг	10	6	60.0	2	20.0	2	20.0
5	Баянговь	17	13	76.5	1	5.9	3	17.6
6	Баянлиг	23	18	78.3	2	8.7	3	13.0
7	Баян-Овоо	14	11	78.6	0	0.0	3	21.4
8	Баян-Өндөр	24	14	58.3	1	4.2	9	37.5
9	Баянцагаан	11	7	63.6	1	9.1	3	27.3
10	Богд	9	7	77.8	0	0.0	2	22.2
11	Бөмбөгөр	19	15	78.9		0.0	4	21.1
12	Бууцагаан	12	9	75.0	2	16.7	1	8.3
13	Галуут	20	13	65.0	1	5.0	6	30.0
14	Гурванбулаг	15	11	73.3	0	0.0	4	26.7
15	Жаргалант	8	8	100.0	0	0.0	0	0.0
16	Жинст	9	7	77.8	1	11.1	1	11.1
17	Заг	7	6	85.7	0	0.0	1	14.3
18	Өлзийт	12	11.0	91.7		0.0	1	8.3
19	Хүрээмарал	13	7	53.8	1	7.7	5	38.5
20	Шинэжинст	6	2	33.3	2	33.3	2	33.3
21	Эрдэнэцогт	10	6	60.0	0	0.0	4	40.0
	Дүн	337	231	68.2	47	11.9	59	19.9

Аудитын илрүүлэлт:

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь аймгийн, сумдын Засаг дарга нар нь сумын Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний тоон болон чанарын хүрэх үр дүнг нэгтгэн тооцоогүй, зорилтод түвшин тодорхойлсон баримт материалыг нэгтгээгүй байна.

Иймд цаашид Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнээс гарах үр дүн, үр ашгийг урьдчилан нэгтгэн тооцож аймгийн хэмжээнд нийгэм эдийн засагт үзүүлэх үр дүнг нэгтгэн тооцож ажиллаж байх зөвлөмжийг аймаг, сумдын Засаг дарга нарт зөвлөмжөөр хүргүүлэв.

Төсөл, арга хэмжээний жагсаалтад дүн шинжилгээ хийж үзэхэд жил бүр хогийн цэг засварлах, гэрэлтүүлэг хийх гэх мэт ажлыг хийж байхад сумд үр дүнг тооцоогүй, сум бүр мал угаалын ванн хийх ажлыг хийж, зураг төсөвт хөрөнгө зарцуулсан байгаагаас үзэхэд дээрх ажлуудыг нэгдсэн нэг зураг, төсвөөр хийвэл зураг төсөвт зарцуулж буй хөрөнгийг хэмнэх боломжтой байна.

Аудитын илрүүлэлт:

Баян-Овоо сумын 2013 онд тус сумд хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөө хийгдэж байсан бөгөөд өмнөх төлөвлөлтийн ажлын үр дүн гараагүй байхад шинээр 70.0 сая төгрөгийн өртөг бүхий хот төлөвлөлтийн ажлыг шинээр баталсан байгаа нь төсвийн хөрөнгийг үргүйдүүлэх эрсдэлтэй байна.

Иймд сангийн хөрөнгөөр 2013 онд хийгдсэн сумын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхгүйгээр 2022 онд дахин шинээр хийхээр 130.0 сая төгрөг баталсан нь төсвийн үрэлгэн зардлыг бий болгож байгаа тул өмнөх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр ашгийг гаргаж ажиллах зөвлөмжийг Баян-Овоо сумын Засаг даргад хүргүүлэв.

2.2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн 232 төсөл, арга хэмжээний хүрсэн үр дүнг тооцоогүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй дараах төсөл арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр өгөхүйц бодит үр дүнг ажил болсон байна. Тухайлбал:

САЙН ЖИШЭЭ:

- ✓ *Галуут сум нь 6 багийн нутаг дэвсгэрт тус бүр 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий мал угаалын ванн, тарилгын хашааг иж бүрнээр нь ашиглалтад оруулсан нь тус сумын 1,2,3,6 дугаар багуудын 147400 бог малыг арьсны гадна шимэгчдээс хамгаалах, сэргийлэх бололцоо бүрдсэн.*
- ✓ *Жаргалант сум нь 9.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Биохимийн шинжилгээний аппаратыг авсан нь сумын 3000 орчим иргэнд лабораторийн шинжилгээг сум орон нутагтаа хийж байна.*
- ✓ *Өлзийт сум 35.0 сая, Заг сум нь 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Хогийн цэгийг дарж булшлах ажлыг гүйцэтгэсэн бөгөөд хуучин төвлөрсөн хогийн цэгийг ландфиллийн аргаар дарж булшлан, шинээр 4 карьер ухаж хогийг ангилан ялгаж байгаа нь иргэд хоггүй цэвэр эрүүл таатай орчинд аюулгүй амьдрах нөхцөл бололцоо бүрдсэн байна.*

- ✓ Заг сум нь 14.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппаратыг ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан бөгөөд сумын 2085 орчим иргэнд лабораторийн шинжилгээг сум орон нутагтаа хийх боломжтой болсон.
- ✓ Баян-Овоо сум нь өмнөх онд хадлангийн тоног төхөөрөмжийг 26.6 сая төгрөгөөр худалдан авч сумын төвийн урд хэсэгт хадлангийн 30 га талбайг хашиж туршилтаар талбайн зарим хэсэгт тариалалтыг хийсэн бөгөөд цаашид тус талбайг бүрэн ашиглавал гамшигийн нөөц бүрдүүлэх ажлын тодорхой хэсгийг дотоодоос хангах түүнийг дагаж ажлын байр нэмэгдэх зэрэг ач холбогдол гарахаар байна.
- ✓ Өмнөх онуудад Залаажинст-Эдрэн үүлдрийн ямааг 2015 онд үүлдрээр, Бөмбөгөрийн улаан омгийн ямааг 2016 онд омгоор, Ламын гэгээний улаан үржлийн хэсгийн тэмээг 2017 онд, Баянбулаг хонийг омгоор 2020 онд тус тус батлуулж, малын ашиг шимийн түвшин сайжран эдийн засгийн эргэлт сайжирсан.



Аймгийн хэмжээнд 1406 хэрэглэгчээс санал асуулга авсан бөгөөд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд нийт иргэдийн 23 хувь буюу 325 иргэн хангалттай сайн гэж хариулсан бол 37 хувь буюу 525 иргэн хангалтгүй, 40 хувь буюу 556 иргэн мэдэхгүй гэж хариулсан байна.

Иймд цаашид сум бүр ажлын байр нэмэгдүүлэх, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангасан сум орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулсан арга хэмжээнүүдийн бодит үр дүнг тооцож, тайлагнах шаардлагатай байна.

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон зарим төсөл, арга хэмжээний техникийн үндэслэл, чанар байдалтай холбоотойгоор ашиглалт хангалтгүй байна.

2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгийг бүрэн гүйцэтгүүлж хүлээн аваагүй, зарим хөрөнгийг хийгдэж дуусаагүй байхад комисс хүлээн авсан зөрчил илрэв. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

1. Бууцагаан сум: Сумын төвийн камержуулалтын засварын ажлыг Зэт Эн Жи ХХК 3.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн ч 1 камер ажиллагаагүй байна.
2. Баянговь сум: “Анагай гурван цоохор” ХХК-ны хийж гүйцэтгэсэн 5.0 сая төгрөгийн өртөг бүхий сурын талбайн ажлыг дуусаагүй байхад хүлээж авсан акт үйлдсэн, “Ханан улаан хайрхан” ХХК-ны хийж гүйцэтгэсэн 10.0 сая төгрөгийн өртөг бүхий мөн орон нутгийн судлах танхимын засвар, тохижилтын ажил дууссан боловч хүлээж аваагүй,
3. Баянлиг сум: “Баян ундрах хайрхан” ХХК-ны гүйцэтгэсэн 36.0 сая төгрөгийн өртөг бүхий “Мах,сүү, цагаан идээ” борлуулах цэгийн комисс хүлээж авсан боловч ашиглалтад ороогүй,

Баянхонгор мэдээлэл холбооны газрын хийж гүйцэтгэсэн 10.0 сая төгрөгийн өртөг бүхий камержуулалтын ажил бүрэн хийгдээгүй, “Дэвших болор” ХХК-ны хийж гүйцэтгэх 6.0 сая төгрөгийн өртөг бүхий “Сумын төвийн камер, гэрэлтүүлэг нэмэгдүүлэх”-ийн ажил бүрэн хийгээгүй,

4. Шинэжинст сум: “Гуа орд” ХХК-ны гүйцэтгэх 160.0 сая төгрөгийн өртөг бүхий “Эрүүл мэндийн төвийн сүрлэн барилгын их засвар”-ын ажил, “Очир заан” ХХК-ны гүйцэтгэх 50,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Халуун усны нэгдсэн халаалтад холбох” ажлууд бүрэн дуусаагүй гэрээний хугацааг баримтлаагүй, ашиглалтад ороогүй байна.

Иймд дээрх дуусаагүй 281.3 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээний ажлуудыг бүрэн гүйцэтгүүлж ашиглалтад оруулах албан шаардлагыг холбогдох сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

Гүйцэтгэгч компани гэрээний хугацааг баримтлаагүй байгаа нь Монгол улсын Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1¹⁸ дэх заалтыг зөрчиж байна.

Аудитын илрүүлэлт:

1. Хүрээмарал сум: “Газар тариалангийн талбайд услалтын систем авах” 10.0 сая төгрөгийн ажлыг хүлээн авсан акт үйлдээгүй, мөн уг хөрөнгийг ашиглаагүй байна.
2. Баянлиг сумын 2.3.4 багийн эмчийн өрөөний тавилга хэрэгслийн 6.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг хүлээн авсан боловч багийн төвд суурилуулаагүй багийн дарга нарын хувийн байранд хураалттай байсан.
3. Баянбулаг сум: “4-р багийн Гүн өрмийн худаг”- ийг 33.3 сая төгрөгөөр бүрэн гүйцэт хийгдсэн ч одоогоор ашиглаагүй, уг худгийг смарт болгосон ч байгаль цаг уурын онцлогоос шалтгаалан ухаалаг систем нь ажиллахгүй, цэвдэгтэй учир шланк хөлдсөн.
4. Шинэжинст сум: ОНХСангийн хөрөнгөөр 2019 оноос эхлэн хийгдсэн 369.2 сая төгрөгийн өртөгтэй “Цэвэр усны байгууламж”-ийг “Их богд оргил” ХХК гүйцэтгэсэн бөгөөд 2020 онд сумын ЗДТГ ажлын хэсэг хүлээн авч ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэсэн боловч өвөл болохоор хөлддөг учир ашиглалтгүй байгаа тул мэргэжлийн байгууллагад шалгуулан хяналт хийлгэж арга хэмжээ авч ажиллах **албан шаардлагыг** хүргүүлэв.


Мөн дээрх орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн үр дүнд бий болсон Хүрээмарал, Баянлиг, Баянбулаг сумдын 49.3 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээний ашиглалтыг сайжруулах албан шаардлагыг холбогдох сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.



ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалтыг иргэдээс санал асуулгаар судалгаа авахад оролцсон нийт иргэдийн 14.3 хувь нь сайн, 28.1 хувь нь ашиглалтын байдал дунд, 15.9 хувь нь хангалтгүй гэж хариулсан бол 41.7 хувь буюу 587 иргэн мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн байна.

¹⁸ гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх

2.3.2. Аймаг сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн үр дүнд бий болсон хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр зохих ашиглагч байгууллагуудад эзэмшүүлсэн ба аудитын нэгдсэн судалгаанаас үзэхэд хадгалалт хамгаалалтын байдал нь хэвийн байна.



“2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хадгалалт, хамгаалалт зохих түвшинд байна уу” гэсэн асуултад нийт иргэдийн 53.8 хувь нь буюу 757 иргэн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл аргар хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт хамгаалалтын

талаар мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна. Үүнээс үзэхэд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт түүний үр дүнд бий болсон хөрөнгө, түүний ашиглалтын талаар иргэдэд хүргэх мэдээлэл хангалтгүй байгааг харуулж байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС ЗӨРЧИЛ ДУТАГДАЛ АРИЛАХГҮЙ БАЙНА.

3.1. Аймгийн ИТХ ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд хяналт тавиагүй, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд тавих хяналт хангалтгүй байна.

3.1.1 ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэлийн явцад аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх хороо хяналт хийх үүргээ хэрэгжүүлээгүй байгаа нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4¹⁹ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд Богд, Галуут, Жаргалант, Заг, Баацагаан, Баянлиг, Баян-Өндөр, Баянцагаан, Шинэжинст, Эрдэнэцогт, Хүрээмарал сумдын ИТХ-аас ажлын хэсэг томилж, төсөл арга хэмжээг түүвэрлэн хяналт хийсэн ба Баянбулаг, Баян-Овоо,

¹⁹ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

Бууцагаан, Гурванбулаг, Баянговь. Жинст сумдын ИТХ хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчил илрэв.,



“Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодитой хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаг уу” гэсэн санал асуулгад оролцсон нийт 1406 иргэний 72 хувь буюу 1018 иргэн ОНХС-ийн хөрөнгөөр орон нутагт хийгдэж бүтээн байгуулалтын ажлууд

бодитой хэрэгжиж буй эсэхэд хяналт тавьдаггүй гэсэн хариулт ирүүлсэн нь дээрх бүтээн байгуулалтын ажлуудад иргэдийн хяналт сул байгааг харуулж байна.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар сумдын ИТХ-ын дарга нарт ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороог байгуулах, хэрэгжсэн төсөл арга хэмжээнд тавих хяналтыг сайжруулж, тайланг ИТХ-аар хэлэлцэж дүгнэлт өгч холбогдох шийдвэр гарган биелэлтийг тооцож байх” зөвлөмжийг өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд сумдын ИТХ-ын дарга нарт Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4 дэх заалтын дагуу ИТХ-ын дэргэдэх хяналтын хороог байгуулан ОНХС-ийн зарцуулалт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах албан шаардлагыг холбогдох аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт хүргүүлэв.

3.1.2. Сумын Засаг даргын захирамжаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээг хүлээн авах комиссыг томилж, ажил тус бүрээр хүлээн авсан бөгөөд Баянговь, Баянцагаан сумдаас бусад сумд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл арга хэмжээг захиалагчийн хяналтыг хууль журмын дагуу хэрэгжүүлж байх зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

“Тогтвортой амьжиргаа 3” төслийн гол зорилго нь хөдөө орон нутагт засаглалыг бэхжүүлж, иргэдийн оролцоотой тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 20 сумд ОНХС-ийн

2021 оны жилийн гүйцэтгэлийн үнэлгээний талаар арга зүйн зөвлөгөө сургалт зохион байгуулсан бөгөөд сумдад журмын дагуу хяналт хийжээ.

ОНХС-ийн үйл ажиллагааг үнэлэхдээ иргэдийн оролцоо болон ОНХС-ийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу хэрхэн удирдан зохион байгуулсан зэрэг 6 бүлгийн 34 үзүүлэлтээр үнэлдэг бөгөөд Гурванбулаг сум эхний байранд орсон бол Баянговь, Баацагаан, Хүрээмарал, Баян-Өндөр, Богд Шинэжинст сумд 80 хувиас бага үнэлгээг авчээ.

Хүснэгт № 5 Баянхонгор аймгийн 2021 оны сум бүрийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, бүлгээр

Сумын нэр	Олон нийтийн оролцоо	Төлөвлөлт	Ил тод байдал	Гүйцэтгэл	ХШҮ	Өмчийн удирдлага	Сумын Үнэлгээ
Гурванбулаг	79%	96%	84%	75%	100%	100%	90%
Бөмбөгөр	94%	96%	89%	76%	69%	94%	88%
Баянцагаан	100%	92%	78%	80%	67%	96%	87%
Буцагаан	98%	84%	70%	89%	92%	89%	86%
Өлзийт	98%	96%	81%	74%	50%	97%	85%
Баянлиг	96%	92%	73%	73%	95%	90%	85%
Эрдэнэцогт	96%	94%	89%	65%	50%	85%	83%
Баянбулаг	93%	97%	76%	55%	93%	81%	83%
Жинст	86%	88%	84%	87%	73%	60%	83%
Галуут	96%	84%	84%	85%	50%	76%	82%
Баянхонгор	100%	96%	62%	62%	88%	76%	81%
Жаргалант	51%	99%	70%	87%	69%	78%	80%
Баян-Овоо	98%	87%	89%	62%	72%	70%	80%
Заг	89%	97%	84%	36%	97%	90%	80%
Шинэжист	86%	84%	89%	67%	50%	90%	79%
Богд	63%	92%	73%	75%	48%	51%	74%
Баян-Өндөр	88%	81%	84%	58%	55%	55%	72%
Хүрээмарал	92%	93%	43%	62%	45%	67%	72%
Баацагаан	78%	64%	81%	59%	43%	60%	65%
Баянговь	80%	80%	62%	40%	89%	20%	63%
Сумдын дундаж	88%	90%	77%	68%	70%	76%	80%

Эх сурвалж: Тогтвортой амьжиргаа-3 төслийн Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ

3.1.3. Аймгийн ЗДТГ нь дотоод хяналтыг хийсэн боловч хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байна. Тухайлбал:

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5²⁰, 9.7²¹-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд

²⁰ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ.

²¹ .Энэ журмын 9.3-т заасан дүгнэлт, Засаг даргын шийдвэрийг тухайн шатны ИТХ-аар жил бүр, төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын мэдээллийн хамт хэлэлцүүлнэ.

хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс Сумдын ЗДТГ-ын үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын хэсэг 2021 оны 11 дүгээр сарын 01-05-ны хооронд аймгийн батлагдсан удирдамжийн дагуу 20 сумын ОНХС-гийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийсэн байна.

Тус хяналт шалгалтаар дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Сумдын Засаг дарга нар ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан сумын Засаг даргын даргын захирамжаар байгуулж, Орон нутгийн хөгжлийн сангийн журмыг мөрдөж иргэдээс санал авч нэгтгэх, эрэмбэлэх ажлыг маягтын дагуу хийж хэвшсэн боловч зарим сумдад эрэмбэлэгдээгүй ажил, арга хэмжээ оруулж батлуулдаг.
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5.1²²-т зааснаар багийн засаг дарга нар нь өмнөх оны ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүн, тухайн онд хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, багийн Иргэдийн нийтийн хурлаар танилцуулах ажил сумдад хангалтгүй байна
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.7.5²³ дах заалтыг зөрчиж Баацагаан сум 2.0 сая төгрөгөөр сумын Цагдаагийн хэсэгт согтуурлын зэрэг шалгах багаж, Баян-Өндөр сум сумын Цагдаагийн хэсэгт 8.0 сая төгрөгөөр суудлын автомашин, Баянлиг сум цаг уурын талбайг стандарт болгох ажилд 8.0 сая төгрөгөөр засварласан, Баянговь сум ЗДТГ-ын чийрэгжүүлэлтийн танхимд 10.0 сая тоног төхөөрөмж авахаар гэрээ хийсэн, Жинст сум Хөдөө аж ахуйн цаг уурын харуулын гадна талбай, хайс хамгаалалтыг 8.0 сая төгрөгөөр засварлахаар гэрээ хийсэн зөрчлүүд илэрсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зөвлөмжийг аймаг сумдын засаг дарга нарт хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийн биелэлтийг ирүүлэх хугацаа заагаагүй учир хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байна.

Иймд хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах зөвлөмжийн биелэлт болон үр дүнг тооцож ажиллах аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст зөвлөв.

²² Баг, хорооны Засаг дарга нь сум, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран өмнөх оны ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүн, тухайн онд ОНХС-ийн болон малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг дараагийн төсвийн жилийн аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тэргүүлэх ач холбогдолтой хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний танилцуулгын хамт бэлтгэж баг, хороо, сум, дүүргийн мэдээ, мэдээллийн хэрэгслээр дамжуулан жил бүрийн 2 дугаар сард багтаан олон нийтэд танилцуулна.

²³ Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ;

Аймгийн Санхүү, хяналт аудитын албанаас 2021 оны ОНХС-ийн үйл ажиллагаанд аудит хийгээгүй байна.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар ОНХС-ийн 2020 оны нийцлийн аудитаар 491.9 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж 20.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 360.2 сая төгрөгийн зөрчил арилгах хугацаатай 9 албан шаардлага, 111.7 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба актыг бүрэн барагдуулсан ба 159.0 сая төгрөгийн 2 албан шаардлага болон 3 зөвлөмж бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт № 6 Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлагын хэрэгжилт

д/д	Илрүүлсэн зөрчлийн товч утга	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн биелэлт
Төлбөрийн акт		
1	Аймгийн спорт хорооны их засварын ажлын санхүүжилтийг гүйцэтгэгч Ханзол ХХК-д аймгийн ИТХ-аас баталсан дүнгээс 20.0 сая төгрөг илүү олгосон.	Гүйцэтгэгч Ханзол ХХК-д олгосон санхүүжилтийг суутган тооцсон.
Албан шаардлага		
1	Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 9.9 сая төгрөгийн өртөг бүхий хүүхдийн тоглоомын талбайг Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэх тогтоол гарсан хөрөнгөд орлогоор бүртгээгүй байна.	Баянхонгор сумын 14 цэцэрлэг нь хүүхдийн гадна тоглоом 9.9 сая төгрөгийг орлого авсан байна.
2	Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн нийтийн эзэмшлийн зам талбайд хог хаягдлын савыг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэхээр шалгарсан "Баян эрдэнийн тогтох" ХХК нь нэг бүр нь 0.5 сая төгрөгийн өртөг бүхий нийт 25 ш хогийн сав хийх байсан ч гүйцэтгэлээр 3.3 сая төгрөгийн 7 ш хогийн савыг хийж, ажлыг дутуу гүйцэтгэсэн байна.	Баян-Эрдэнийн тогтох ХХК нь 2020.06.02-ний өдөр Баянхонгор сумын Нийтийн эзэмшлийн талбайд хог хаягдлын савыг нэмэгдүүлэх гэрээ байгуулан ажилласан ба тухайн ХХК нь ажил гүйцэтгэсэн тайланг ирүүлсэн байна.
3	Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хотын төвд шинээр 5 автобусны буудал бий болгох ажлыг гүйцэтгэхээр шалгарсан "Дурсамж принтинг" ХХК -ны гүйцэтгэсэн автобусны буудлыг хүлээж авах ажлын хэсэг томилогдсон ч хүлээн авч, акт үйлдээгүй байна.	Баянхонгор сумын Засаг даргын 2020.10.19-ний өдрийн 4/225 тоот захирамжаар томилогдсон ажлын хүлээн авсан актыг үйлдсэн байна.
4	Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 6.0 сая төгрөгийн өртөг бүхий Иргэний танхимын засварын ажлыг "Хийморь Од"ХХК- гүйцэтгэж дууссан боловч тус ажлыг хүлээн авч, акт үйлдээгүй байна.	Баян-Овоо сумын ЗДТГ-ын иргэний танхимын урсгал засварын ажлыг 2021.04.28-ний өдрийн 02 дугаар актаар хүлээн авсан байна.
5	Баянговь, Хүрээмарал сумын үүрэн телефоны сүлжээний өргөтгөлийн барилгын ажлыг дуусган хүлээлгэн өгсөн боловч Хүрээмарал суманд Gtobail үүрэн утасны сүлжээ ороход нарны гэрэлтүүлгийн хүчин чадал хангалттай бус, Баянговь суманд тавигдсан нарны толиноос 2 ширхэг нь хагарч ашиглах боломжгүй болсон зэргээс шалтгаалан үүрэн утасны сүлжээ ороогүй ОНХС-ийн хөрөнгийн үр нөлөө гараагүй байна.	Баянхонгор аймгийн Засаг даргын 2021.06.17 өдрийн 5/908 тоот албан бичгээр зөрчлийг арилгасан албан тоот ирүүлсэн байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

6	Эрдэнэмандал сургуулийн гаднах спорт цогцолбор талбайн тохижилтын ажлыг гүйцэтгэгч "Есөн од констракшн ХХК нь 2019.06.21-ны өдрийн №03 тоот 79.5 сая төгрөгийн гэрээ байгуулан 2020.03.19-ны өдөр 47.7 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч ажлын гүйцэтгэл гаргаагүй, хөл бөмбөгийн талбайн хайс, гоолын хаалга хийгдсэн сандал, сараалжин торыг худалдан авсан боловч угсарч суурилуулаагүй байна.	Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн гадна спорт цогцолбор талбайн тохижилтын ажлын гүйцэтгэгч “Есөн од контракшн” ХХК нь хөл бөмбөгийн талбайн бетоны ажил, хайс, гоолын хаалга зэргийг гүйцэтгүүлсэн байна.
7	Аймгийн спорт хорооны их засварын ажлын гүйцэтгэл дутуу, чанаргүй хийгдсэн байхад комисс хүлээн авсан тул гүйцэтгэгч Ханзол ХХК –аар дутуу, чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийлгүүлэх хүлээн авах.	“Хан зол” ХХК-аар Баянхонгор аймгийн Спорт хорооны их засварын ажилд гарсан зөрчил дутагдлыг аргилгаж 2021 оны 9 дүгээр сард хүлээлгэн өгсөн байна.
8	Баянхонгор аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр "Баянхонгор сумын гэр хороололын өнгө үзэмжийг иргэдийн оролцоотой сайжруулах төсөл хэрэгжүүлэх" ажлыг 60.3 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр "Очир заан" ХХК-тай гэрээ байгуулан ажиллуулсан боловч гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон.	Баянхонгор сумд эрх шилжсэн мөртлөө санхүүжилтын эрх шилжээгүйгээс гүйцэтгэлд хяналт тавилгүй аймгаас санхүүжилтыг бүрэн олгосон. Баянхонгор сумаас хяналт хийхэд 80 хувийн гүйцэтгэлтэй байсан. Биелэлт 80 хувь
9	Баянхонгор аймгийн ОНХС-гийн ОНХС-ийн 271.1 сая төгрөгийн хөрөнгөөр "Аймгийн төвийн 2,3,7,9 дүгээр багийн гэр хороололын гэрэлтүүлэг, камержуулалт, интернет орчин бүрдүүлэх, гамшгийн үеийн дохиоллын сирена суулгах" ажлыг "Баттод" ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байх бөгөөд улмаар гүйцэтгэгч тал 2019 онд 40.0 сая, 2020 онд 150.0 сая төгрөгийн санхүүжилтийг захиалагчаас авч гэрэлтүүлэг, камержуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн боловч сервер өрөөний тохижилт, аваарын дохионы ажлууд хийгдээгүй, хүлээлгэж өгөөгүй байна.	Тухайн ажлыг бүрэн хүлээж аваагүй.
Зөвлөмж		
1	Сумын ИТХ-аар батлаагүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлдэг байдлыг зогсоож, цаашид ОНХС-гийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 60.3.1 заалтад нийцэхгүй төсөл арга хэмжээг ИТХ-р баталж, зарцуулахгүй байхад анхаарч ажиллах.	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна..
2	Орон нутгийн хөгжлийн сангийн орлого сүүлийн 3 жил биелээгүйгээс төлөвлөгдсөн ажлууд хэрэгжих боломжгүй болж байгаа тул хандив тусламжийн орлогыг бодитоор төлөвлөж байх.	Аймгийн орон нутгийн хөгжлийн санд 577.2 сая хандив авахаар төлөвлөсөн боловч 84.0 сая төгрөгийн хандив орсон, Баян-Овоо сум 125.0 сая төгрөгийн хандив авахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 55.0 сая, Галуут сум 120.0 сая төгрөгийн хандив авахаар төлөвлөсөн боловч 45.0 сая төгрөгийн хандив төвлөрсөн байгаа нь хандив тусламжийн орлогыг бодитоор төлөвлөөгүй өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29.4-т заасны дагуу ТЭЗҮ-ийг магадлалаар баталгаажуулсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зураг төсөвт тусгагдаагүй ажилд нэмэлт гэрээ байгуулсан төсөвт хүндрэл учруулж байгааг зогсоох.	Зарим сумдын иргэдээс санал аваагүй, ТЭЗҮ зураг төсөвгүй төсөл арга хэмжээг ИТХ-аар хэлэлцүүлэн баталж, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
4	Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2017 оноос эхлэн баригдаж байгаа “Бөмбөгөр сумын спорт заал бүхий оффис”-ын барилгад 335.0 сая төгрөгийг зарцуулсан ба дуусаагүй барилгын ажлыг мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан барилгын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулах талаар арга хэмжээ авч ажиллах.	Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2017 оноос эхлэн баригдаж байгаа “Бөмбөгөр сумын спорт заал бүхий оффис”-ын ажлыг ТЭЗҮ-ийг магадлалаар оруулсны дараа өмнөх хийсэн ажлын зөрүүгээр гүйцэтгэхээр бэлтгэж байна.
5	Өмнөх аудитаар албан шаардлагаар өгсөн хэрэгжилт хангалтгүй байгаа төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах талаар тодорхой ажил зохион байгуулж, төрд учирсан хохирлын барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах	“Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитаар “Хонгорын шугуй” ХХК нь Баянхонгор-Өлзийт чиглэлийн замын дагуу мод тарих, Баянхонгор сумын ойн зурвасын хамгаалалтыг сайжруулах, аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын урьдчилгаа санхүүжилтийг аваад гэрээний үүргээ биелүүлээгүй гэрээнд заасан ажлыг гүйцэтгээгүй тул албан шаардлага өгсөн ч одоо болтол уг ажил хэрэгжээгүй байна. Биелэлт 0%

Эх сурвалж: 2020 оны статистик мэдээ

Иймд 2019 онд хийгдсэн нийцлийн аудитаар “Хонгорын шугуй” ХХК нь Баянхонгор-Өлзийт чиглэлийн замын дагуу мод тарих, Баянхонгор сумын ойн зурвасын хамгаалалтыг сайжруулах, аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 100.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ТАХ, “Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр “Аймгийн төвийн 2,3,7,9 дүгээр багийн гэр хороололын гэрэлтүүлэг, камержуулалт, интернет орчин бүрдүүлэх, гамшгийн үеийн дохиоллын сирена суулгах” 271.1 сая төгрөгийн ТАХ, “Баянхонгор сумын гэр хороололын өнгө үзэмжийг иргэдийн оролцоотой сайжруулах төсөл хэрэгжүүлэх” 60.3 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй тул албан шаардлага хүргүүлсэн ч одоо болтол хэрэгжээгүй дээрх ажлуудыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх албан шаардлагыг аймаг, сумын Засаг даргад хүргүүлэв.

3.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу тайлагнасан байна.

3.2.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2²⁴-д заасны дагуу 2021

²⁴ 9.2.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9- д заасан мэдээллийг багтаана.

онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг сумд аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т журамд заасан хугацаанд ирүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь дээрх журмын 9 дүгээр зүйлийн 9.9²⁵-д заасны дагуу аймаг, сумдын 2021 оны ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж Сангийн яаманд аймгийн Засаг даргын 2022.02.15-ний өдрийн 1а/102 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 12 төсөл арга хэмжээний 107.8 сая төгрөгийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байгаа нь ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4²⁶, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн заавар”-ын 8.6²⁷-д бүртгэнэ гэж заасныг зөрчсөн байна.

Аудитаар хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн бүртгэл тайлантай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ.

Аудитын илрүүлэлт

- *Жаргалант сум: Гэрэлтүүлгийн 3.3 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй.*
- *Бууцагаан сум: Явган замын 3.0 сая төгрөг, хогийн сав хийсэн 5.0 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, мөн сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 5/10 тоот тогтоолоор ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн эзэмшигчийн тогтоох тогтоол гарсан бөгөөд уг тогтоолд дутуу хэрэгжсэн, огт хэрэгжээгүй ажилд эзэмшигч тогтоосон, мөн багуудад хөрөнгө эзэмшүүлэхээр тогтоосон.*
- *Жинст сум: Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө 29.0 сая, нийтийн эзэмшлийн талбайн засвар 6.5 сая, худаг сэргээн засварлах 3.0 сая, төв худгийн халаалт 5.0 сая төгрөгийн ажлыг ИТХ-аас тогтоол гараагүйгээс хөрөнгөнд орлого аваагүй байна.*
- *Баян-Өндөр сум: Эмнэлгийн моргийн хөргөгч 6.5 сая төгрөгийг хүлээн аваагүй байхад Эрүүл мэндийн төв нь үндсэн хөрөнгөнд орлого авсан байна.*
- *Баянговь сум: Нийт 53.0 сая төгрөгийн өртөгтэй 6 ТАХ-г хүлээж авсан ИТХ-аас тогтоол гаргаагүйгээс бүртгэлд тусгаагүй байна.*

Дээрх 107.8 сая төгрөгийн хөрөнгийн эзэмшигчийг тогтоож, нягтлан бодох бүртгэлд тусгах албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

3.2.3. Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд дутуу, алдаатай оруулж байгаа,

²⁵ 9.9. Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана.

²⁷ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ.

аймгийн ОНХС-ийн мэдээллийг хангалтгүй оруулж байгаагаас үзэхэд журмаар зохицуулсан санхүүжилтийн хөшүүргийг хэрэгжүүлж ажиллахгүй байна. Тухайлбал:

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын 10.2²⁸-т заасны дагуу tusuv-oronnutag.mof.gov.mn сайтад Баянхонгор аймаг болон сумдын ОНХС-ийн хөрөнгө, оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг оруулсан байдлыг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ.

Аудитын илрүүлэлт

- Бууцагаан сум:Төлөвлөлтийн шатны мэдээллийг бүрэн гүйцэт оруулсан бөгөөд хэрэгжилтийн шатны ажлыг иргэдээс санал аваагүй ТАХ-г ИТХ-аар баталснаас гүйцэтгэлийг бөгөөд ижил төсөөтэй ТАХ-ээр орлуулан мэдээлснээр уг ажилд олгосон санхүүжилт зэрэг нь зөрүүтэй,
- Баян-Овоо сум төлөвлөлт болон хэрэгжилтийн шатны зарим мэдээлэл дутуу, мөн тогтоол шийдвэрүүдийг оруулаагүй, Жаргалант сум: Хэрэгжилтийн шатны зарим мэдээлэл дутуу, мөн тогтоол шийдвэрүүдийг оруулаагүй,
- Баацагаан, Баян-Өндөр сумд: ОНХС-ийн зарцуулалт, үр дүнгийн талаар бүрэн оруулаагүй,
- Баянговь сум: ИТХ-аар батлагдсан төсөл арга хэмжээг дутуу оруулсан, ОНХС-ийн зарцуулалт үр дүнг оруулаагүй,
- Богд сум: Багийн ИНХ-аас эрэмбэлсэн ажлыг дутуу оруулсан,
- Жинст сум: ИТХ-аар батлагдсан худгийн халаалт, нийтийн ариун цэврийн байгууламж, нохой устгалын зардлыг оруулаагүй,
- Эрдэнэцогт сум: 2021 онд тодотгосон төсвийг тус тус оруулаагүй
- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг огт оруулаагүй байна.

Иймд ОНХС-ийн хөрөнгө, оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв, ил тод, нээлттэй мэдээлж байх зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлж байна.

Мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийг удирдлагын мэдээллийн системд оруулаагүй байгаа тул мэдээллийг оруулах албан шаардлага өгөв.

Тус аудитын төлөвлөлтийн үе шат буюу 2022.03.17-ний байдлаар аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийг удирдлагын мэдээллийн системд оруулсан байдлыг татаж харахад хангалтгүй үзүүлэлттэй байсан бөгөөд аудитын явцад тус системд мэдээллийг бүрэн оруулах талаар зөвлөмж өгсөн дагуу нийт гэрээний дүн 484.0 сая, зарцуулалт 370.0 сая, санал өгсөн иргэд 122,827 хүнээр, гүйцэтгэгчид 73, хэрэгжиж буй ажлын тоо 18, гүйцэтгэлийн хувь 1 хувиар, ашиглалтад орсон ажлын тоо 18-аар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

²⁸ ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ.

Хүснэгт № 7 Удирдлагын мэдээллийн системийн мэдээлэл

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Санхүүжилт төсөв	Нийт гэрээний дүн	Зарцуулалт	Санал өгсөн иргэд	Гүйцэтгэгчид	Хэрэгжиж буй ажлын тоо	Гүйцэтгэлийн хувь	Ашиглалтад орох ажлын тоо
2022.03.17-ний өдрийн байдлаар	7,782.00	2,968.00	5,027.0	2,285.0	3,884	521	286	77%	277
2022.06.07-ний өдрийн байдлаар	7,782.00	2,968.00	5,511.0	2,655.0	126,711	594	304	78%	295
Зөрүү	-	-	484.00	370.00	122,827	73	18	1%	18


Эх сурвалж: Tusuv-oronnutag.mof.gov.mn сайтаас



Санал асуулгад оролцсон нийт иргэдийн 66 хувь нь ОНХС-ийн талаар мэдээлэл хангалтгүй гэж хариулсан бол мэдээлэл авдаг иргэдийн 32.7 хувь нь орон нутгийн мэдээллийн самбар, радио, телевиз, сошиалаар, харин 18.6 хувь нь баг хорооны Засаг дарга, хэсгийн ахлагчаас авдаг гэсэн байгаа нь иргэд сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын талаарх мэдээллийг хүргэх суваг хангалтгүй байгааг харуулж байна.

“Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль, тогтоомж, журам, зааврыг судалж үзсэн үү” гэсэн асуултад санал асуулгад оролцсон нийт иргэдийн 70 хувь нь ОНХС-ийн талаарх хууль, тогтоомж, журам, зааврыг судлаагүй гэж хариулснаас үзэхэд иргэд төсвийн эрх мэдлийг хэрэгжүүлэх боломжид ач холбогдол өгөхгүй байна.

Дүрслэл №10 Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль, тогтоомж, журам, зааврыг судалж үзсэн үү?





иргэдэд мэдээлэл хүргэх хэлбэр хангалтгүй байгааг харуулж байна.

3.2.4. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансанд нэгдсэн цахим хуудсанд цаг тухайд мэдээлээгүй байна.

ОНХС-ийн 2021 санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж 276.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Аудитаар нийт 3,710.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 41.5 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 2,966.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 19 албан шаардлага өгч, 703.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 7 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн нэгдсэн сангаас олгогдох орлогын шилжүүлэг бүрэн олгогдож байгаа ч орон нутаг 822.2 сая төгрөгийн хандивын орлого төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 184.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.
2. Зарим сумд иргэдээс санал аваагүй, ТЭЗҮ зураг төсөв хийгдээгүй төсөл арга хэмжээг төлөвлөж, ИТХ-аар батлуулсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²⁹, 60 дугаар зүйлийн 60.3.6³⁰ дахь заалтуудыг зөрчсөн байна.
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийг зөрчсөн байна.
4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрэх үр дүн, нийгэм, эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг тооцоогүй байна.
5. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон зарим төсөл, арга хэмжээний техникийн үндэслэл, чанар байдалтай холбоотойгоор ашиглалт хангалтгүй байна.
6. Баянговь, Баянцагаан сумдаас бусад сумууд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
7. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу тайлагнасан байна.
8. Аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, тайлагналыг удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулаагүй, иргэдэд хүргэх мэдээлэл хангалтгүй байна.

-оОо-

²⁹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

³⁰ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

НЭГ. АЙМАГ, СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

1. Иргэдээс санал аваагүй мөн ТЭЗҮ, зураг төсөв хийгдээгүй төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлуулдаг байдлыг таслан зогсоож, цаашид хуульд заасан техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулж байх.
2. Барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг төсөв батлагдсан даруйд зохион байгуулж, мөн ижил төрлийн ТАХ-г жижиглэхгүй байх.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрэх үр дүн, нийгэм, эдийн засаг үзүүлж буй үр нөлөөг тооцож ажиллах.
4. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл арга хэмжээг захиалагчийн хяналтыг хууль дүрмийн дагуу хэрэгжүүлж байх.
5. ОНХС-ийн хөрөнгө, оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг үнэн зөв, ил тод, нээлттэй байдлаар иргэд олон нийтэд хүргэж байх.
6. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2013 онд хийгдсэн сумын ерөнхий төлөвлөгөөтэй давхардуулан дахин ерөнхий төлөвлөгөө хийхгүй байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 12 дугаар сарын 05 -ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

-оОо-